

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ"
ХХК-ийн ТУЗ-ийн 2026 оны 03 дугаар
/дүгээр/ сарын 23 ны өдрийн 26/20
тоот тушаалын хавсралт 1



SOLOMON INVESTMENTS

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ ХИЙХ ЖУРАМ

Баримт бичгийн төрөл/ Type:
журам

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх

Хамрах хүрээ/ Area:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ийн
ажилтнуудад

Нууцын зэрэглэл/ Confidentiality:

Дотоодод нээлттэй

Баримт бичгийн дугаар/Number:

М/26/34

Боловсруулсан/ Prepared by:

.....

Баталсан/ Approved by:

"СОЛОМОН ИНВЕСТМЕНТС ББСБ" ХХК-ийн
Гүйцэтгэх захирал

Хуудасны тоо/ Page number:

5 хуудас

Хянан нийцүүлэх давтамж:

Минд 1 удаа

Батлагдсан огноо/ Effective date:

2026 оны 03 дүгээр сарын 23

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам (цаашид "журам" гэх)-аар "Соломон Инвестментс ББСБ" ХХК (цаашид "Компани" гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, аливаа этгээдтэй хэлцэл хийхдээ ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сонирхлын зөрчлийг хүлээн зөвшөөрч болох хэмжээнд удирдах, улмаар сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий этгээдээс зөвшөөрлөөр хийх журмыг тодорхойлох, учирч болзошгүй болон учирсан сонирхлын зөрчлийг таньж түүний учруулж болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахтай холбоотой харилцааг зохицуулна.
- 1.2. Журам нь Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Компанийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх холбогдох журам болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 1.3. Компани нь үйл ажиллагаандаа Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Компанийн засаглалын кодексыг дагаж мөрдөнө.

ХОЁР. НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

- 2.1. Энэхүү баримт бичигт дурдагдах дараах нэр томьёо болон товчилсон үгийг доор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

Сонирхол.	Хувь хүн эсхүл бүлэгт нөлөөлж болох аливаа зүйлийг
Хувийн ашиг сонирхол	Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд өөрөө болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн зүгээс нөлөөлж болохуйц эдийн болон эдийн бус ашиг сонирхлыг
Ашиг сонирхлын зөрчил	Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэх үед түүний хувийн ашиг сонирхол албан үүргээ тэгш, шударгаар хэрэгжүүлэхэд харшаар нөлөөлж болохуйц нөхцөл байдлыг
Хамаарал бүхий этгээд	Тухайн албан тушаалтны эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагч, эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, төрсөн ах, эгч, дүү, бусад нэгдмэл сонирхолтой этгээдийг

ГУРАВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ

- 3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл: Компанийн энгийн хувьцааны 20 (хорь) буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай доор дурдсан харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд хэмээн үзнэ. Үүнд:
 - 3.1.1. хэлцлийн нөгөө тал, эсхүл хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа;
 - 3.1.2. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл уг хэлцэлд төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20-оос дээш хувийг дангаараа буюу түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;
 - 3.1.3. хэлцлийн нөгөө тал болон оролцож байгаа, эсхүл төлөөлөгч буюу зуучлагчаар оролцож байгаа хуулийн этгээдийн толгой компанийн эрх бүхий албан тушаалтан, эсхүл уг компанийн энгийн хувьцааны /ногдол хувийн/ 20 буюу

түүнээс дээш хувийг дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа;

3.1.4. хэлцлийн үр дүнд шууд буюу шууд бусаар үүсэх орлогоос хувь хүртэж байгаа.

3.2. **Нэгдмэл сонирхолтой этгээд:** Дараах этгээдийг нэгдмэл сонирхолтой этгээд гэж үзнэ.

Үүнд:

3.2.1. Тодорхой гэрээний үндсэн дээр хамтран тухайн компанийн удирдлагын шийдвэрийг тодорхойлох боломж бүхий бүлэг хүмүүс;

3.2.2. Компанийн нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан

3.2.3. Компанийн удирдлагын шийдвэрийг хамтран тодорхойлох боломж бүхий компани болон хүн /бүлэг хүмүүс/

3.2.4. нэг хүн /бүлэг хүн/ гаргах шийдвэрийг нь тодорхойлох боломж бүхий компани;

3.2.5. Компани болон уг компанийн эрх бүхий албан тушаалтан

3.2.6. Нэг гэр бүлийн гишүүн, эцэг, эх, хүүхэд, ач, зээ нар ах дүү, бусад төрөл, садангийн хүн

3.2.7. Нэг хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцаа эзэмшигчид

3.2.8. Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь хувьцааны хяналтын багцыг эзэмшдэг болон эрх бүхий албан тушаалд ажилладаг компани, уг компани оролцогч нь болж байгаа компанийн нэгдлийн бусад оролцогч компани болон тэдгээрийн хувьцааны хяналтын багцыг эзэмшигч болон эрх бүхий албан тушаалтан

3.2.9. Уг этгээд ажил олгогч бол түүний ажилтан

3.3. **Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тавих шаардлага:**

3.3.1. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/ болон аудиторыг шаардлагатай мэдээллээр хангах үүрэгтэй.

3.3.2. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээд нь уг хэлцлийн талаар шийдвэр гаргахад оролцох эрхгүй.

3.3.3. Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж, сонирхогч этгээд үзэх боломжоор хангах үүрэгтэй.

3.4. **Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам:** Компани нь сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тохиолдолд дараах журмын дагуу хийнэ. Үүнд:

3.4.1. Компанийн нэрийн өмнөөс аливаа этгээдтэй хэлцэл байгуулах зорилгоор хэлэлцээрт орж буй этгээд нь нэн түрүүнд уг хэлцэл нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд хамаарах эсэхийг нягтлан шалгана.

3.4.2. Компанийн эрх бүхий этгээд нь хэлцэл хийхэд сонирхлын зөрчил үүсэхээр бол энэ талаар төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-д тухай бүр мэдэгдэнэ.

3.4.3. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана.

3.4.4. Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно.

- 3.4.5. Сонирхлын зөрчилтэй хэлцэл /хоорондоо уялдаатай хэд хэдэн хэлцэл/ хийх, хараат болон охин компанид сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх буюу шаардах шийдвэрийг дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж хуралд оролцож байгаа сонирхлын зөрчилгүй хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор гаргана. Үүнд:
- 3.3.5.1. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон хэлцлийн үнэ буюу эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрх, үйлчилгээний үнэ хөлс нь хэлцэл хийх тухай шийдвэр гаргах үеийн бүртгэлийн үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 3.3.5.2. Компанийн гаргах энгийн хувьцаа, энгийн хувьцаа худалдан авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаасны хэмжээ нь компанийн буюу түүний хараат хувьцаат компанийн урьд нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн 25 хувиас их байх;
- 3.3.5.3. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүх гишүүн нь /хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус бүх гишүүн/ хэлцэл хийх сонирхол бүхий этгээд байх.
- 3.4.6. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг төлөөлөн удирдах зөвлөлийн хэлцэл хийх талаар сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхын саналаар, хувьцаат компанийн хувьд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн олонхын саналаар гаргана.
- 3.4.7. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх тухай энэ журмыг тодорхой төрлийн хэлцэл хийхэд баримтлах хууль буюу компанийн дүрэмд заасан журмын хамт нэгэн зэрэг баримтална.
- 3.4.8. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг гагцхүү бичгээр байгуулна.

ДӨРӨВ. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЛИЙН УЛМААС ҮҮСЭХ ҮР ДАГАВАР

- 4.1 Энэ журмын 3.1-д заасан этгээдтэй байгуулсан хэлцлийг шүүх хүчин төгөлдөр бус гэж тооцож болно.
- 4.2 Дараах шаардлагыг хангаж байгаа тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг хүчин төгөлдөрт тооцно. Үүнд:
- 4.2.1 Энэ журмын хуулийн 3.4 дүгээр зүйлд заасан журам зөрчсөн бөгөөд уг зөрчлийн талаар энэ хэлцлийг байгуулсан этгээд мэдээгүй болон мэдэх боломжгүй байсан нөхцөлд;
- 4.2.2 Хэлцлийг байгуулсан эрх бүхий этгээд нь хувийн ашиг сонирхолгүй, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар хэлцлийг зөвшөөрсөн бөгөөд уг зөвшөөрөл нь шударга ёсонд нийцсэн байх;
- 4.2.3 Сонирхлын зөрчил байхгүй хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар зөвшөөрсөн байх;
- 4.2.4 Хэлцэл нь компанийн хувьд зүй ёсны, шударга байх
- 4.3. Энэ журмын 3.1-д заасан этгээд нь хуульд заасан шаардлага, журам зөрчсөн, эсхүл компанигай хэлцэл байгуулсан хуулийн этгээдийн бүх хувьцааг уг этгээд дангаараа эзэмшдэг нөхцөлд компани нь учирсан хохирлыг тухайн хуулийн этгээдээр нөхөн төлүүлэх буюу энэ хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.
- 4.4. Компанийн энгийн хувьцаа эзэмшигч, эсхүл компани нь энэ журмын 3.1-д заасан этгээд, эсхүл уг этгээдийн дангаараа бүх хувьцааг эзэмшдэг хуулийн этгээдээр компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр итгэмжлэлгүйгээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй.

ТАВ. ХАРИУЦЛАГА

- 5.1. Компанийн эрх бүхий албан тушаалтан нь тухайн албан тушаалд томилогдсоноос хойш 10 хоногийн дотор өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг гаргаж, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргад өгөх бөгөөд уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь 10 хоногийн дотор компанид мэдэгдэнэ.
- 5.2. Энэ журмын 3.1-д заасан этгээд нь хуульд заасан шаардлага, журам зөрчсөний улмаас компани буюу түүний хараат болон охин компанид учруулсан хохирлын хэмжээгээр, эсхүл хэлцлийн үр дүнд авсан зүйлээс олсон ашгийн хэмжээгээр хариуцлага хүлээнэ.
- 5.3. Сонирхлын зөрчилтэй хэлцлийн улмаас компани, түүний хараат болон охин компанид учирсан хохирлыг гэм буруутай этгээд өөрийн хөрөнгөөр нөхөн төлнө.
- 5.4. Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн компанийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.